



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/172

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” зорилтот жилийн хүрээнд малын тэжээлийн тариалалтад хэрэглэгдэх 100 тонн малын тэжээлийн үрийн үнэ 95,000,000 (ерэн таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Батлагдсан төсвийн дагуу малын тэжээлийн үр нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданям)-д үүрэг болгосугай.

3.Шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж ажиллахыг байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

4.Дээрх зардлыг зорилтод жилийн төсвөөс гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100376